



# МОНГОЛ ОРНЫ ЖИГҮҮРТЭН ШУВУУД ФОТО ЗУРГИЙН УРАЛДААН

Монголын зэрлэг амьтан судлах хамгаалах төв болон Монголын шувуу ажиглагчдын клуб хамтран эх орныхоо жигүүртэн шувууд болон амьдрах орчны тухай фото зургын уралдаан зарлаж байна.

Уралдаан нь НҮБ-ээс 2010 оныг Биологийн төрөл зүйлийг хамгаалах олон улсын жил болгосонтой уялдуудан Монголын ард иргэдийг байгаль хамгаалах, түүний дотроос жигүүртэн амьтадыг хамгаалах үйлсэд татан оролцуулах, иргэдийн дунд шувуу ажиглах сонирхолыг хөхүүлэн дэмжих зорилгоор зохион байгуулагдаж байгаа оршино.

Уралдаанд ирүүлэх бүтээл нь байгаль дээр авсан зэрлэг шувууны зураг, эсвэл шувууд ба амьдрах орчины тухай байх ёстой. Хашаанд, зуслангийн эдлэнд авсан зураг байж бас болно. Шувууны өндөг, ангаахайн зургийг хүлээн авах боломжгүй.

Уралдаанд оролцохыг хүсэгчид фото зураг, материалаа 2010 оны 9 дүгээр сарын 15-ны дотор [info@wsc.org.mn](mailto:info@wsc.org.mn) хаягаар ирүүлнэ үү.

Нэг оролцогч авсан зурагнуудаасаа шилж сонгосон 1-3 бүтээлж явуулах ёстой.

Нэг зургийн файлын хэмжээ 10МВ-аас хэтрэх ёсгүй. Мөн хамгийн өндөр нягтшилаараа байвал сайн. Пиксель муутай зургийг оролцуулах боломжгүй. Дараах төрлийн файлуудыг хүлээн авна, .jpg, .gif, and .png.

Уралдаанд ирүүлж багаа бүтээл нь нэр, зураг авсан он сар өдөр, газрын нэртэй байхаас гадна, зурагчин өөрийн овог нэр, нас, мэргэжил, холбоо барих и-майл хаяг, утасны дугаараа ирүүлсэн байх ёстой.

Шувууны өндөг, ангаахайн зургийг шалгаруулах боломжгүй. Зурган дээр хүн, мал шувуудын хамт гарсан байж болно.

Уралдаанд шалгарсан зурагчинтай и-майлээр холбоо барих бөгөөд ЗАСХТ, МШАК-ын вебсайт дээр зарлан тавих болно. Мөн шалгарсан бүтээлийг нийтийн хүртээл болгох үүднээс дээрх вебсайт дээр байрлуулж сурталчилах болно.

Уралдаанд ирүүлсэн бүтээлээс нэг зургыг шилдэгээр шалгаруулж тэргүүн байрны шагнал, гэрчилгээ олгох болно. Тэргүүн байранд орсон оролцогчид гэрчилгээ, “Зүүн Азийн шувууд”, “Монгол дахь шувуудад чухал нутгууд” номыг бэлэглэх ба мөн удаах байранд орсон хоёр бүтээлийг шалгаруулж тусгай шагнал, “Монгол дахь шувуудад чухал нутгууд” номыг бэлэглэх болно.

Уралдааны шагналт байранд зөвхөн Монгол улсын иргэл болон манай улсад ажиллаж амьдарч байгаа гадаадын иргэдийг шалгаруулана. Харин гадаадын жуулчид болон шувуу ажиглагчид материалаа ирүүлж чөлөөтэй оролцож болно.

Уралдаанд ирсэн фото зургуудын зохиогчын эрх бүтээлээ ирүүлсэн зурагчинд хадгалагдах болно. Гэхдээ энэхүү уралдаанд зургаа ирүүлсэнээр оролцогчид өөрсдийн бүтээлээ ЗАСХТ болон МШАК-т үнэгүй, ашгийн бус зорилгоор ашиглах, мөн өөрийн нэр, бүтээлийг уг уралдаантай холбоотой аливаа төрлийн сурталчилгаанд ашиглах эрх олгож байгаагаа хүлээн зөвшөөрч байна гэж үзнэ.

